



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН  
АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: СЭА-2023/25-17-ШТА-ГА

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХӨДӨӨ АЖ АХУЙН  
САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮР НӨЛӨӨ БҮХИЙ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЭГҮЙ, ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА

Сүхбаатар сум 2023 он



**Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа**

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

**Аудитын менежер Б.Батмөнх**

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

**Ахлах аудитор Т.Болор**

Утас: 70362442 Цахим хаяг:

[bolort@audit.gov.mn](mailto:bolort@audit.gov.mn)

**Аудитор О.Анхбаяр**

Утас: 70362442 Цахим хаяг: [ankhbayaro@audit.gov.mn](mailto:ankhbayaro@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

<b>АГУУЛГА</b>	
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, зургийн товьёг	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
<b>БҮЛЭГ А: ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА УУ?</b>	7
А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцэж байна уу?	7
А.2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт хангалттай байна уу?	9
<b>БҮЛЭГ Б: ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ҮР ӨГӨӨЖТЭЙ БАЙНА УУ?</b>	13
Б.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна уу?	13
Б.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийг тогтоосон хугацаанд үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	14
<b>БҮЛЭГ В: ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?</b>	17
В.1. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна уу?	17
В.1. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна уу?	19
АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ	21
ДҮГНЭЛТ	22
ЗӨВЛӨМЖ	22
САНАЛ	24

## Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГБХН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УИХ	Улсын Их хурал
ХАА	Хөдөө, аж ахуй
ХААДС	Хөдөө, аж ахуйг дэмжих сан
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төслийн мэдээлэл	6
Хүснэгт 2	Зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдал	7
Хүснэгт 3	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан байдал	9
Хүснэгт 4	Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн судалгаа	9
Хүснэгт 5	Трактор, ХАА-н техникийн зээлийн эргэн төлөлт	11
Хүснэгт 6	“Ургац Ерөө” хоршооны тариалалт, борлуулалтын мэдээ	16
Хүснэгт 7	Шилэн дансны мэдээлэл байршуулалт	17
Хүснэгт 8	Засгийн газрын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээ	18
Хүснэгт 9	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байдал	19
Хүснэгт 10	Удирдлагын мэдээллийн системд оруулсан мэдээлэл	20

## Зургийн товъёг:

Зураг 1	Зээлийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний хэрэгжилтийн байдал	12
Зураг 2	Өсөх буудай ХХК-ийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр	13
Зураг 3	Ерөө суманд баригдсан 500 м2 өвлийн хүлэмж	15
Зураг 4	Ерөө суманд баригдсан 100 тн-ы зоорь	15

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт:**

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- ✓ Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- ✓ Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;

### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд болон төслийн нэгж, хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын үйл ажиллагаа, 2016-2022 оны хооронд тус аймагт хэрэгжсэн 6 төслийн 12,068,069.5 мянган төгрөг, 374.5 мянган еврогийн төсөвт өртөгтэй 30 иргэн, аж ахуйн нэгжийн зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамруулав.

Аудитыг Засгийн газрын шугамаар болон хандивлагч орон, олон улсын байгууллагаас хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон гадаад зээл, тусламжийн мэдээ, төслийн нэгжийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангууд, дамжуулан зээлд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын зээлтэй холбогдох үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, бусад нотлох баримт материалд үндэслэн хийлээ.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-3200-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт *MNS 6817-3:2020 “Төрийн аудит. Чанарын хяналт”*, *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”*, *MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”*-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, нийцлийн аудитын холбогдох

стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он);
- Шилэн дансны тухай хууль (2014 он);
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор О.Анхбаяр нар 2023 оны 05 дугаар сарын 30-аас 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Сэлэнгэ аймгийн хэмжээгээр /2016-2022 оны байдлаар/ Монгол Улсын Засгийн газрын түншлэгч орон, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 11,021,398.5 мянган төгрөгийн, 374.5 мянган еврогийн санхүүжилттэй 5 төслийн 29 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төслийн мэдээлэл

№	Төслийн нэр нэр	Зээл	Буцалтгүй тусламж	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	
					Мянган төгрөг	Мянган евро
1	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	1		19		374.5
2	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох	1		4	1,600,000.0	
3	"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл	1		2	2,000,000.0	
4	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй	1		1	5,871,398.5	
5	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	1		3	1,550,000.0	
6	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл		1	1	1,046,671.0	
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>30</b>	<b>12,068,069.5</b>	<b>374.5</b>

Эх сурвалж: ХАА-н салбарын зээл, тусламжийн нэгтгэсэн судалгаа

Харин буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 1,046,671.0 мянган төгрөгийн санхүүжилттэй 1 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

ХАА-н салбарын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төслүүдийн сонгон шалгаруулалт ХХААХҮЯ-д хийгдсэн бөгөөд нэгдсэн мэдээлэл, аудитад шаардлагатай баримт материал орон нутагт байхгүй байна.

## БҮЛЭГ А. ХӨДӨӨ АЖ ЗЭЭЛИЙН ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦАА ДУУСААГҮЙ БАЙХАД ХУДАЛДАН БОРЛУУЛСАН БАЙНА

### А.1 ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД НЬ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ НИЙЦЭЖ БАЙНА

**А.1.1** Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1<sup>1</sup>, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 5.1.1<sup>2</sup>-д Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь Монгол Улс, Засгийн газрын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого болон хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан байхаар заажээ.

**А.1.2** Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>3</sup>, 6.7<sup>4</sup>-д заасны дагуу УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг тус тус баталсан байна.

**А.1.3** Гадаадын зээлийн хөрөнгөөр тус аймагт хэрэгжиж буй 5 төслийг “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн “Найм. Бүс, орон нутгийн хөгжил” гэсэн үндсэн зорилгын “Тогтвортой хөдөө аж ахуй 8.3: Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” зорилтуудтай тус тус нийцүүлэн төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байдал

№	Төслийн нэр	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн		Алсын хараа 2050	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
			Мянган төгрөг	Мянган евро			

<sup>1</sup> 6.2.1. Засгийн газар, орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их Хурлаас баталсан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;

<sup>2</sup> 5.1.1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн байх;

<sup>3</sup> 6.2. 30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх "Алсын хараа" нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна.

<sup>4</sup> 6.7. Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

1	Зээлийн батлан даалтын сан	4	1,600,000.0		8.3 зорилтын 1 үе шатын 2, 5, 6	8.3.4-8.3.6	8.3.2, 8.3.6
2	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл	2	2,000,000.0		8.3 зорилтын 1 үе шатын 6, 7	8.3.6, 8.3.14	4.3.1, 8.3.2
3	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	3	1,550,000.0		8.3 зорилтын 1 үе шатын 6	8.3.4, 8.3.6, 8.3.11	8.3.2, 8.3.3, 8.3.6
4	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй	1	5,871,398.5		8.3 зорилтын 1 үе шатын 4, 6	8.3.11	8.3.2
5	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	19		374.5	8.3 зорилтын 1 үе шатын 3	8.3.10	8.3.3
	<b>Дүн</b>	<b>29</b>	<b>11,021,398.5</b>	<b>374.5</b>			

Эх сурвалж: Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд

**A.1.4** Мөн дээрх нийт 11,021,398.5 мянган төгрөг, 374.5 мянган еврогийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.3.1<sup>5</sup>, 8.3.2<sup>6</sup>, 8.3.3<sup>7</sup>, 8.3.6<sup>8</sup> дахь зорилтуудтай нийцэж байна.

**A.1.5** Өрийн удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1<sup>9</sup>, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 5.1-д Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байхаар заажээ.

**A.1.6** Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1.12<sup>10</sup>-т заасны дагуу УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т дээр дурдсан 5 төслийн тусгагдсан эсэхийг тодруулахад дараах байдалтай байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

<sup>5</sup> 4.3.1. “Орон нутгийн онцлог, нөөцөд суурилсан чанар, стандартын шаардлага хангасан, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Сум бүрд нэг үйлдвэр-үйлчилгээ” арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

<sup>6</sup> 8.3.2. “Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлэн эрдэм шинжилгээний байгууллагууд, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.”

<sup>7</sup> 8.3.3. “Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин, хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлж, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ.”

<sup>8</sup> 8.3.6. “Монгол мал-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулна.”

<sup>9</sup> 23.3.1. энэ хуулийн 18.5.1-18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байх;

<sup>10</sup> 4.1.12. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг;

Хүснэгт 3. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан байдал

№	Төслийн нэр	Тусгагдсан эсэх
1	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл	Тийм
2	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл	Тийм
3	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй	Тийм
4	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Үгүй
5	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	Үгүй

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

**A.1.7** Дээрх төслүүдийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Улс болон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцүүлэн төлөвлөсөн боловч “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 2 төсөл нь тусгагдаагүй байна.

## **A.2 ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ САНГААР ДАМЖУУЛАН ЗЭЭЛЭЭР ХУДАЛДСАН ТРАКТОР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУВААРЬТ ТӨЛБӨР БҮРЭН ТӨВЛӨРӨӨГҮЙ БАЙНА**

**A.2.1** Өмнөх хэсэгт дурдсан 5 төслийн хөрөнгөөр тус аймагт иргэн, аж ахуйн нэгжийн нийт 29 төсөл, арга хэмжээ /Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав./ хэрэгжиж байна. Үүнд:

- Зээлийн батлан даалтын сан: 1,600,000.0 мянган төгрөгийн 4 ,
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл: 2,000,000.0 мянган төгрөгийн 2,
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл: 1,550,000.0 мянган төгрөгийн 3,
- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй: 5,871,398.5 мянган төгрөгийн 1,
- Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл: 374.5 мянган еврогийн 19 иргэн, аж ахуйн нэгж.

**A.2.2** “Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл”, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл”-ийн хөрөнгөөр арилжааны банкаар дамжуулан 9 аж ахуйн нэгжид 5,150,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Арилжааны банкаар дамжуулан ААН-д олгосон зээлийн судалгаа

/мянган төгрөгөөр/

№	Харилцагчийн нэр	Зээлийн дүн	Зориулалт, төслийн нэр	Санхүүгийн зуучлагч банк	Эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа	Тайлбар
1.	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл						

*Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж*

1	Газрын Ундраа ХХК	300,000.0	Үр тариа тариалах	ХААН	2018.04.30	2021.04.30	2020.10.09 зээл бүрэн төлөгдсөн
2	Гэцэлцэцүүх БГБХН	100,000.0	Үнээний ферм байгуулах, өргөжүүлэх	Хас	2018.06.27	2028.06.27	2021.05.31 зээл бүрэн төлөгдсөн
3	Энххос Мөрөн ХХК	360,000.0	Үтрэмээ нүүлгэх	Капитрон	2019.06.17	2025.02.17	2022.06.15 зээл бүрэн төлөгдсөн
4	Өсөх Буудай ХХК	840,000.0	Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Төрийн банк	2018.10.01	2028.10.01	Төлөлт хэвийн
	<b>Дүн</b>	<b>1,600,000.0</b>					
<b>2. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт</b>							
1	Өгөөж мандал уул ХХК	1,400,000.0	Үрийн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	Хаан	2018.10.12	2023.11.01	Төлөлт хэвийн
2	Михачи ХХК	600,000.0	Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	Голомт	2018.10.12	2025.10.01	Төлөлт хэвийн
	<b>Дүн</b>	<b>2,000,000.0</b>					
<b>3. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл</b>							
1	Өгөөмөр хан тайж ХХК	400,000.0	Усалгааны системээр шар буурцаг тариалах төсөл	Голомт	2018	2023	Төлөлт хэвийн
2	Шинэ мандах ХХК	350,000.0	Мах, сүүний үнээний ферм өргөжүүлэх төсөл	Хаан	2019	2028	Төлөлт хэвийн
3	Шинэ тариа ХХК	800,000.0	Газар тариалангийн техник технологи шинэчлэх төсөл	Капитрон	2022	2032	Төлөлт хэвийн
	<b>Дүн</b>	<b>1,550,000.0</b>					
	<b>Нийт дүн</b>	<b>5,150,000.0</b>					

*Эх сурвалж: ХАА-н салбарын зээл, тусламжийн нэгтгэсэн судалгаа*

**A.2.3** Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл”-ийн хөрөнгөөр үр тариа тариалах, үтрэм нүүлгэх, үнээний ферм байгуулж, өргөжүүлэх, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 аж ахуйн нэгжид Хаан, Хас, Капитрон, Төрийн банкаар дамжуулан 1,600,000.0 мянган төгрөгийн зээл олгосноос 3 зээлийн эргэн төлөлтийг хуваарьт хугацаанаас нь өмнө бүрэн төлсөн бол 1 зээлийг хугацаандаа төлж, төлөлт хэвийн байдалтай байна.

**A.2.4** Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт”-ийн хөрөнгөөр үрийн үйлдвэрлэлийн болон зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр 2 аж ахуйн нэгжид Хаан, Голомт банкаар дамжуулан 2,000,000.0 мянган төгрөгийн зээл олгосон, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

**A.2.5** Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл”-ийн хөрөнгөөр усалгааны системээр шар буурцаг тариалах, мах, сүүний үнээний ферм өргөжүүлэх, газар тариалангийн техник технологи шинэчлэх хүрээнд 3 аж ахуйн нэгжид Хаан, Голомт, Капитрон банкаар дамжуулан 1,550,000.0 мянган төгрөгийн зээл олгосноос төлөлт хугацаандаа хийгддэг, хэвийн байдалтай байна.

**A.2.6** Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн Газрын санхүүжилтээр хэрэгжиж буй “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн хөрөнгөөр ХААДС-аар дамжуулан 19 иргэн, аж ахуйн нэгжид 541.5 мянган еврогийн трактор, тоног төхөөрөмж зээлээр олгосноос урьдчилгаа 30 хувь болох 162.8 мянган еврог төлүүлж, үлдсэн төлбөр 378.7 мянган еврог 3 жилд тэнцүү хувааж төлөхөөр гэрээ байгуулсан байна.

**A.2.7** Зээлийн эргэн төлөлтийг тулган баталгаажуулахад 2022 онд иргэн, аж ахуйн нэгжүүд 103.8 мянган еврог төлөхөөс 87.3 мянган еврог төлсөн бол доор дурдсан 2 иргэн 16.5 мянган еврогийн зээлийн төлбөрийг графикайн дагуу гүйцэтгээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Трактор, ХАА-н техникийн зээлийн эргэн төлөлт

/мянган евро/

№	Харилцагчийн нэр	Зээлийн дүн	2022 онд төлөх	Дамжуулан зээлдэгч	Эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа	Тайлбар
1	Ш.Батбаяр	23.7	8.2	ХААДС	2021	2024	Хугацаандаа төлөгдөөгүй
2	Б.Болдбаатар	23.7	8.2	ХААДС	2021	2024	Хугацаандаа төлөгдөөгүй
	<b>Дүн</b>	<b>47.5</b>	<b>16.5</b>				

Эх сурвалж: Тракторын эргэн төлөлт

**A.2.8** Дээр дурдсан 4 зээлийн гүйцэтгэлийн байдлаас харахад арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн хөрөнгийг ашиглагч талаас гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд биелүүлж, /зээлийн эргэн төлөлт хэвийн, зарим зээлийг хугацаанаас өмнө төлсөн/ зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа бол ХААДС-аар дамжуулан зээлээр худалдсан зарим трактор, ХАА-н техникийн 2022 онд төлөгдөх төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

**A.2.9** Харин Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл”-ийн хөрөнгөөр Сант сумын Ивэн голын усалтын системийн ажлыг “Бридж констракшн” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилга угсралтын ажлын гэрээнд тусгагдсан нийт ажил 2023 оны 06 дугаар сарын байдлаар 63 хувьтай хийгдсэнийг Барилгын хөгжлийн төвөөс баталгаажуулсан байна.

**A.2.10** Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн ТАХ-ний ашиглалтыг газар дээр нь тулган баталгаажуулахад авсан зээлийг иргэн, аж ахуйн нэгжүүд зориулалтын дагуу ашигласан байна. Тухайлбал:

Зураг 1. Зээлийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний хэрэгжилтийн байдал



“Бридж констракшн” ХХК -ийн гүйцэтгэж буй “Ивэн голын усалтын систем”-ийн барилгын явц / Сант сум /



Михачи ХХК-ийн зөгийн бал боловсруулах тоног төхөөрөмж / Сүхбаатар сум /



Өгөөмөр хан тайж ХХК-ийн 60 га талбайн усалгааны систем / Жавахлант сум /




Шинэ тариа ХХК-ийн худалдан авсан газар тариалангийн техник / Ерөө сум /

**А.2.11** Харин “Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн дараах 2 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө оруулалтын ажлыг зээлийн эргэн төлөлтийн хугацаа дуусаагүй байхад худалдан борлуулсан байна. Үүнд:

- Гэцэлцэцүүх БГБХН нь үнээний ферм байгуулах, өргөжүүлэх зориулалтаар 100,000.0 мянган төгрөгийн зээл авч, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор фермийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй болсон гэх үндэслэлээр аж ахуйн нэгжийг худалдан борлуулж, уг хөрөнгөөр зээлийг хугацаанаас нь өмнө барагдуулсан байна. Одоо Баянгол суманд оршин суудаггүй гэх шалтгаанаар холбогдох мэдээлэл, баримт материал байхгүй байна.
- Өсөх буудай ХХК нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар 840,000.0 мянган төгрөгийн зээл авч, Сэлэнгэ Meat фүүдс нэртэй мал нядалгааны газрыг 2019 онд ашиглалтад оруулснаар 2022 оныг хүртэл үйл ажиллагаа явуулж байсан байна. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тус нядалгааны цехийг Тайсу Ман ХХК-д худалдан борлуулж, тус хөрөнгөөр Мандал сумын нутагт Акуа Сэ цэвэр усны үйлдвэрийг барьж ашиглалтад оруулсан байна.

Зураг 2. Өсөх буудай ХХК-ийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр /Сүхбаатар сум/



**А.2.12** Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг харьяалах аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон бусад холбогдох байгууллагуудаас тодорхойлолт, санал авахгүйгээр сонгож, мэдээлэл хүргэхгүй байгаа нь эдгээр төсөл, хөтөлбөрүүдийн талаар аймаг, орон нутаг, ямар ч мэдээлэлгүй, улмаар хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох боломжгүй байдалд хүргэж байна.

## **БҮЛЭГ Б. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА**

### **Б.1 ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ САЛБАРЫН БОДЛОГОТой УЯЛДСАН БАЙНА**

**Б.1.1** Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.1<sup>11</sup>-д тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан байхаар заажээ.

**Б.1.2** Тусламжийн хөрөнгөөр тус аймагт хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл” нь “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн “Найм. Бүс, орон

<sup>11</sup> Тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ дараах шаардлагыг хангасан байна.

нутгийн хөгжил” гэсэн үндсэн зорилгын “8.3:Тогтвортой хөдөө аж ахуй” зорилтуудад нийцсэн байна.

**Б.1.3** Мөн дээрх төслийг батлагдах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.13<sup>12</sup>, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн 3.1.1<sup>13</sup>, 3.1.2<sup>14</sup>, 3.2.3<sup>15</sup>-д заасан зорилтуудтай уялдсан байна.

## **Б.2 ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЬ ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ УЧИР БҮРЭН АШИГЛАГДАХГҮЙ БАЙНА**

**Б.2.1** Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр тус аймгийн Ерөө суманд 1,046,671.0 мянган төгрөгийн “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл”-ийг “Ургац-Ерөө” хоршоогоор дамжуулан хэрэгжүүлж байна.

**Б.2.2** Дээрх төслийн хүрээнд нийт 917,496.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг олгосон байна. Үүнд:

- 66,880.0 мянган төгрөгийн өртөг бүхий 4\*8-ын харьцаатай 20, 6\*20-ын харьцаатай 10 ширхэг, нийт 30 ширхэг хүлэмж,
- 69,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 50 морины хүчтэй трактор 1 ширхэг,
- 84,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Мотоблок, дагалдах хэрэгслүүдийн хамт тус бүр 5 ширхэг,
- 229,619.0 мянган төгрөгийн өртөг бүхий өвлийн хүлэмж 1 ширхэг,
- 449,297.2 мянган төгрөгийн өртөг бүхий 100 тонны зоорь 1 ширхэг,
- 18,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий борлуулалтын ТҮЦ 2 ширхэг.

**Б.2.3** “Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 м<sup>2</sup> өвлийн хүлэмж барих” ажлын худалдан авах ажиллагааг 2020 онд ХХААХҮЯ-наас зохион байгуулж, “Мандал өргөө голомт” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулан, 229,619.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2021 оны 08 дугаар сард барилгын ажлыг дуусгаж, хүлээлгэн өгсөн байна.

<sup>12</sup> Өвөл, зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурины хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах.

<sup>13</sup> Өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурины хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах

<sup>14</sup> Орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх

<sup>15</sup> Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Зураг 3. Өвлийн хүлэмжийн гадна, дотор талаас /Ерөө сум/




**Б.2.4** Өвлийн хүлэмжид 2021 оны 8 сараас эхлэн тариалалт хийсэн боловч 2021 оны 11 сарын 19-ээс эхлэн **хөрсөнд хөлдөлт явагдаж**, өвлийн улиралд ашиглах боломжгүй болсноор тариалалтыг зогсоосон байна.

**Б.2.5** 2022 он 03 дугаар сард Ерөө суманд 25км/ц-ийн хурдтай салхилсны улмаас хүлэмжийн дээврийн 3 поликарбонат, дулаалгын 4 хучлага урагдаж уг гэмтлийг засварлах зардлыг “Хоршооны дахин хөрөнгө оруулалтын хамтын сан”-ийн санхүүжилтээс гарган засварласан байна.

**Б.2.6** Тусламжийн эх үүсвэрээр “Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 100 тонны багтаамжтай хүнсний ногооны агуулах барих” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022 онд ХХААХҮЯ зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Грийтволл Ковер” ХХК-ийг сонгон шалгаруулан 49,297.2 мянган төгрөгөөр гэрээ байгуулсныг 2023 оны 3 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

**Б.2.7** Ашиглалтад өгсний дараа хүчтэй борооны улмаас агааржуулалтын хоолойгоор ус орсноор доторх чийгшил нэмэгдэн, **цахилгааны гэмтэл гарч**, гэмтлийг засварлалат зоорийг ашиглах боломжгүй болсон байна.

Зураг 4. Зоорины гадна тал /Ерөө сум/



**Б.2.8** Өөрөөр хэлбэл тусламжийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд чанарын шаардлага хангахгүй байгаа учир зориулалтын дагуу ашиглах боломжгүй байдалд хүрч зорилго, зорилтоо бүрэн хангаж чадаагүй байна.

**Б.2.9** Төсөл хэрэгжүүлэх нэгжээс “Хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний Хавсралт 2-т дурдсан түлш шатахуун, талбайн болон засвар үйлчилгээний ажлын хөлс, ногооны үр, сэлбэг хэрэгсэл худалдан авах зэрэгт зарцуулах 129,174.8 мянган төгрөгийг олгохоос 2022 онд “Ургац-Ерөө” хоршоонд дахин хөрөнгө оруулалтын хамтын сангийн санхүүжилт нэрээр 64,462.8 мянган төгрөг олгож, үлдэгдэл санхүүжилт болох 64,712 мянган төгрөгийг 2023 онд санхүүжүүлэхээр байна.

**Б.2.10** “Ургац-Ерөө” хоршооны дансанд шилжүүлсэн 64,462.8 мянган төгрөгийг төслийн зохицуулагчийн 2023.01.12-ны өдрийн Б/06 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу төслөөс олгосон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг засварлахад зарцуулахаас 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр **47,310.0** мянган төгрөгийг нярав Л.Туяагаар 2 дугаар гарын үсэг зуруулан хоршооны дарга С.Даваасүрэнгийн хувийн /ХААН 5679079799 тоот/ харилцах дансанд шилжүүлж, зарцуулсан байна.

**Б.2.11** Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг: 20.1.3-т “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна.

**Б.2.12** Үүнээс дээрх гэрээний хавсралтад дурдаагүй нэг бүр нь 3,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6 ширхэг хүлэмжийг 18,000.0 мянган төгрөгөөр, мод усалгааны дуслын систем 1,750.5 мянган төгрөгөөр худалдан авсан буюу нийт **19,750.5** мянган төгрөгийн төслийн санхүүжилтийг **зориулалт бусаар** зарцуулсан байна.

**Б.2.13** Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд “Ургац-Ерөө” хоршооны нийт гишүүд нь хүлэмжээр болон ил талбайд 2020-2021 онд 84.5 га-д тариалалт хийж, 740 тн-ы ургац хураан, 557,798.0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн гэж дурджээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. “Ургац Ерөө” хоршооны тариалалт, борлуулалтын мэдээ

/мянган төгрөг/

Он	Тариалсан талбай (га)	Хураан авсан ногоо (тн)	Борлуулсан ногоо (тн)	Борлуулалт
2020	39.6	331	212	202,644.0
2021	44.9	409	372	355,154.0
<b>Дүн</b>	<b>84.5</b>	<b>740</b>	<b>584</b>	<b>557,798.0</b>

Эх сурвалж: Төслийн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

**Б.2.14** “Ургац-Ерөө” хоршоог 2021 оны 8 сард байгуулсан боловч санхүүгийн тайлан бэлтгэж, холбогдох байгууллагуудад тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй.”, 14 дүгээр зүйлийн 14.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж,

байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Б.2.15** Төслийн хүрээнд хоршооны 10 бүлгийн дунд 5 мотоблок, 20 гишүүнд 4\*8-ын харьцаатай хүлэмж, 10 гишүүнд 6\*20-ийн харьцаатай хүлэмжийг хүлээлгэн өгснөөс **3 өрх** хүлээн авсан хүлэмжээ огт ашиглаагүй, бусад хөрөнгө бүрэн ашиглагдаж байна гэж тайлагнажээ.

**Б.2.16** Төсөл анх хэрэгжихэд хүнсний ногоо тариалдаг 71 өрхийн 224 иргэн хамрагдсан боловч гишүүдийн хамтын ажиллагаа, оролцоо, идэвх хангалтгүй байна.

**Б.2.17** Дээрх төсөл хэрэгжиж дуусаагүй, санхүүжилтийг төслийн хаалтын хугацаанд бүрэн олгож, санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн учир төслийн хэрэгжих хугацааг сунгасан бөгөөд тусламжийн хүрээнд бий болсон 917,496.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүртгэл, тайланд бүртгэж, тайлагнаагүй байна.

## **БҮЛЭГ В. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

### **В.1 ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН ОЛГОЛТ, ХЭРЭГЖИЛТ, АШИГЛАЛТАД ҮР НӨЛӨӨ БҮХИЙ ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА**

**В.1.1** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6<sup>16</sup>-д Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэхээр тогтоосон байна.

**В.1.2** Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг байршуулж, ил тод болгосон эсэхийг шалгаж үзэхэд 2022 онд 141, 2021 онд 39, 2020 онд 81 мэдээллийг /улсын хэмжээгээр/ тус тус хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Шилэн дансны мэдээлэл байршуулалт

№	Төслийн нэр	Хугацаа хоцроосон мэдээллийн тоо		
		2022	2021	2020
1	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл	9	15	25
2	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	2	0	-
3	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй	29	6	18
4	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	100	16	28
5	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	1	2	10
6	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	ТХН-гүй	ТХН-гүй	ТХН-гүй
	<b>Дүн</b>	<b>141</b>	<b>39</b>	<b>81</b>

<sup>16</sup> 3.2.6. Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;

**В.1.3** “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” нь төслийн нэгжгүй учраас шилэн дансны цахим хуудсанд бие даасан цэсгүй, нээлттэй, ил тод бус байна.

**В.1.4** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2-т заасны дагуу Сангийн яам нь Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг мэдээлэх чиг үүрэгтэй боловч зээлийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Засгийн газрын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээ

/4 дүгээр улирлаар/

№	Төслийн нэр	Зээл, тусламжийн ашиглалтын мэдээ		
		2022	2021	2020
1	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл	Тийм	Үгүй	Тийм
2	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	Үгүй	Тийм	Тийм
3	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй	Тийм	Тийм	Тийм
4	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	Тийм	Тийм	Үгүй
5	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Үгүй	Үгүй	Үгүй
6	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	Үгүй	Тийм	Үгүй

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас:[old.shilendans.gov.mn](http://old.shilendans.gov.mn)

**В.1.5** Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шилэн дансны мэдээллийг бүрэн хөтлөөгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>17</sup>, 5 дугаар зүйлийн 5.1.1<sup>18</sup>, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5.2<sup>19</sup>-т заасныг тус тус зөрчсөн байна.

**В.1.6** Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д аймгийн ИТХ, 10.2-т аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- **Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал** өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1:өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих, 10.1.3:тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт хэлэлцэх, хэрэгжилттэй холбогдуулан чиглэл өгөх,
- **Аймгийн Засаг дарга** өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.2.2:тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих”.

**В.1.7** Гэтэл аймгийн ИТХ болон Засаг даргын зүгээс дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй, зээлийн хэрэгжилт, ашиглалтад хяналт хийгээгүй буюу зээл,

<sup>17</sup> 3.1.1. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

<sup>18</sup> 5.1.1. шилэн дансны бие даасан цэстэй байх;

<sup>19</sup> 6.5.2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр;

тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний талаар огт мэдээлэлгүй, нэгтгэсэн тооцоо, судалгаа хийгдээгүй байна.

## **В.2 УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ХӨТӨЛЖ ХЭВШЭЭГҮЙ БАЙНА**

**В.2.1** Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5<sup>20</sup>, Засгийн газрын 2016 оны 176 тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 23.2<sup>21</sup>, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.6<sup>22</sup>-д зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусгасан байна.

**В.2.2** Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр ХАА-н салбарт хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэд төсөл хэрэгжүүлэх нэгжүүдээс тухай бүр дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна.

**В.2.3** Харин ХХААХҮЯ-наас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэхийг тус яамны цахим хуудаснаас тулган шалгаж, үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байдал

/хувиар/

№	Төслийн нэр	Хяналт-шинжилгээ, үнэлгээ			
		2019	2020	2021	2022
1	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	-	-	Үгүй	Үгүй
2	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл	Үгүй	86.5	97.5	94.0
4	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл	-	80.2	85.5	48.0
5	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	91.8	86.7	86	Үгүй
6	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	86.7	70	74.0	52.9

Эх сурвалж: ХХААХҮЯ-ы хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан: [mofa.gov.mn](http://mofa.gov.mn)

<sup>20</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсөл хэрэгжүүлэгч нь тухайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд шаардлагатай бол холбогдох хяналтын байгууллага, албан тушаалтныг оролцуулж болно.

<sup>21</sup> 23.2. ХШҮ-ний ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр дараа жилийн эхний улиралд багтаан хийх бөгөөд үнэлгээний тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн үнэлгээний тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулна. ТХН нь тайланг ТУХ-нд тухай бүр танилцуулж, холбогдох мэдээлэл, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна.

<sup>22</sup> 10.6. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж, тайланг Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн энэ журмын 14 дүгээр хавсралтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр болон цахим системээр тайлагнана.

**В.2.4** “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” нь бие даасан төслийн нэгжгүй учраас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй бол “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл”-д хяналт-шинжилгээ, үнэлгээ огт хийгдээгүй байна.

**В.2.5** Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 13 дугаар зүйлд удирдлагын мэдээллийн системд дараах байдлаар мэдээллийг хөтлөхөөр тусгасан байна. Үүнд:

- Сангийн яам нь Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системийн удирдлагыг хэрэгжүүлж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх,
- ТЕЗ, Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь гадаад зээлийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, ашиглалт, бүртгэл, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хяналт, үнэлгээ, тайлагналыг тухай бүр цахим систем ашиглан гүйцэтгэн ил тод байдлыг хангах бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах.

**В.2.6** Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 13.1.10, 18.1, 23.1, 23.2, 24.7, 24.9, 24.10, 24.11, 25.3, 25.6-д цахим мэдээллийн системд /odamis.mof.gov.mn/ төслийн үйл ажиллагааны хэрэгжилт болон санхүүжилтийн зарцуулалтын мэдээлэл, хяналт-шинжилгээний тайлан, төсөл хэрэгжиж дууссаны дараа хийгдэх төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, төслийн эцсийн тайланг оруулахаар тусгажээ.

**В.2.7** Удирдлагын мэдээллийн системд зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг бүртгэх байдлыг тулган баталгаажуулахад тус аймагт хэрэгжиж буй 6 төслийн 4 нь төслийн явц, хяналт-шинжилгээний тайланг оруулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Удирдлагын мэдээллийн системд оруулсан мэдээлэл

№	Төслийн нэр	Оруулах мэдээлэл		
		Хийгдэх ажил	Төслийн явцын тайлан	Хяналт-шинжилгээний тайлан
1	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	Үгүй	Үгүй	Үгүй
2	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл	Тийм	Үгүй	Үгүй
3	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл	Тийм	Тийм	Тийм
4	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл	Тийм	Тийм	Тийм
5	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Үгүй	Үгүй	Үгүй
6	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	Тийм	Үгүй	Үгүй

**В.2.8** Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд үр дүнд суурилсан хяналт, шалгалт-үнэлгээ хийх зорилгоор “Удирдлагын мэдээллийн систем”-ийг нэвтрүүлсэн боловч мэдээллийн санг бүрэн хөтөлж хэвшээгүй байна.

**В.2.9** Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25.6<sup>23</sup>, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 12.5<sup>24</sup>-д зааснаар төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад холбогдох дүрэм, журмын дагуу хүлээлгэн өгөхөөр заажээ.

**В.2.10** Тус аймагт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүд бүрэн хэрэгжиж дуусаагүй учир төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

## АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **67,060.5** мянган төгрөгийн, **16.5** мянган еврогийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн хөрөнгөөр ХААДС-аар дамжуулан зээлээр олгосон трактор, тоног төхөөрөмжийн 2022 оны эргэн төлөлтөөс 2 иргэн **16.5** мянган еврогийн төлбөрийг гүйцэтгээгүй,
- “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл”-ийн хоршооны дахин хөрөнгө оруулалтын хамтын сангийн санхүүжилтийн **47,310.0** мянган төгрөгийг “Ургац-Ерөө” хоршооны дарга С.Даваасүрэнгийн хувийн дансанд шилжүүлж, зарцуулсан бөгөөд нярав Л.Туяагаар 2 дугаар гарын үсэг зуруулж, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулсан.
- “Ургац-Ерөө” хоршоо нь 3,000.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэ бүхий 6 ширхэг хүлэмжийг 18,000.0 мянган төгрөгөөр, мод усалгааны дуслын системийг 1,750.5 мянган төгрөгөөр худалдан авч нийт **19,750.5** мянган төгрөгийн төслийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан.

<sup>23</sup> ТХН нь төслийн эцсийн тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн эцсийн тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлнэ.

<sup>24</sup> Төсөл хэрэгжүүлэх нэгж нь хөрөнгийн бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу хөтөлж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад болон дуусгавар болсны дараа төсөл хэрэгжүүлэгч байгууллагад холбогдох дүрэм, журмын дагуу хүлээлгэн өгч, энэ тухай акт үйлдэн баталгаажуулсныг үндэслэн бүртгэл хөтөлж, цахим системээр тайлагнана.

## ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцэж байна.
- Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан зээлээр худалдсан трактор, тоног төхөөрөмжийн хуваарьт төлбөр бүрэн төвлөрөөгүй байна.
- Хөдөө аж зээлийн үр дүнд бий болсон зарим хөрөнгө оруулалтыг эргэн төлөлтийн хугацаа дуусаагүй байхад худалдан борлуулсан байна.
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Зээл тусламжийн хөрөнгийг хувийн харилцах дансаар дамжуулан, зарцуулсан байна.
- Тусламжийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд чанарын шаардлага хангахгүй байгаа учир зориулалтын дагуу ашиглах боломжгүй байдалд хүрч зорилго, зорилтоо бүрэн хангаж чадаагүй байна.
- Зээл, тусламжийн хөрөнгийн олголт, хэрэгжилт, ашиглалтад үр нөлөө бүхий хяналт-шалгалт хийгдээгүй байна.
- Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн хөтөлж хэвшээгүй байна.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар аймаг, орон нутаг ямар ч мэдээлэлгүй байгаа нь хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүргэж байна.

## ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

**Аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа-д:**

- Өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хяналт тавих.
- Зээллэгийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт хэлэлцэх, хэрэгжилттэй холбогдуулан чиглэл өгөх.

**Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:**

- Зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих.

**Аймгийн ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр-д:**

- Зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хөдөө аж ахуйн салбарын төсөл хэрэгжүүлэх нэгжүүдтэй хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Т.БОЛОР

О.АНХБАЯР

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



### СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,  
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081  
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn  
Цахим хуудас: www.selenge.gov.mn


2023.08.18 № 01/1390

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_

### СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.

  
Н. ХАГВАДОРЖ

430801604



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.18 № 87  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийж гүйцэтгэсэн аудитын тайланг хүргүүлэв.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

018030133

C:/Bichig hereg/2023/Alban bichig A5.Docx



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/16

Сүхбаатар сум

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг ҮАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ-ын дарга /Б.Нарантуяа/, Засаг дарга /Н.Лхагвадорж/, ХХААГ-ын дарга /Б.Мөнхтөр/ нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Т.Болор/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

018010045

## ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР СЭЛЭНГЭ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

№	Харилцагчийн нэр	Зээл, тусламжийн нэр	Хэмжээ	Зориулалт, төслийн нэр
1	Газрын Ундраа ХХК	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл /мянган төгрөг/	300,000.0	Үр тариа тариалах
2	Гэцэлцэцүүх БГБХН		100,000.0	Үнээний ферм байгуулах, өргөжүүлэх
3	Энххос Мөрөн ХХК		360,000.0	Үтрэмээ нүүлгэх
4	Өсөх Буудай ХХК		840,000.0	Махан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх
5	Өгөөж мандал уул ХХК	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт /мянган төгрөг/	1,400,000.0	Үрийн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх
6	Михачи ХХК		600,000.0	Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх
7	Бридж констракшн ХХК	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй /мянган төгрөг/	5,871,398.5	Ивэн голын услалтын систем
8	Ургац-Ерөө хоршоо	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /мянган төгрөг/	1,046,671.0	-
9	Өгөөмөр хан тайж ХХК	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл /мянган төгрөг/	400,000.0	Усалгааны системээр шар буурцаг тариалах төсөл
10	Шинэ мандах ХХК		350,000.0	Мах, сүүний үнээний ферм өргөжүүлэх төсөл
11	Шинэ тариа ХХК		800,000.0	Газар тариалангийн техник технологи шинэчлэх төсөл
<b>Дүн</b>			<b>12,068,069.5</b>	
12	Ачит-Оргил ХХК	Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл /мянган евро/	23.7	Трактор, тоног төхөөрөмж
13	Баасансүрэн		23.7	
14	Батбаяр		23.7	
15	Батзаяа		11.6	
16	Болдбаатар		23.7	
17	Ганбат		12.1	
18	Ганболд		11.6	
19	Итёрнал флэйм ХХК		24.9	
20	Монгол сафари ХХК		33.0	
21	Мөнх-Орхон ХХК		21.7	
22	ПУБОСС ХХК		18.1	
23	Рэд дот ХХК		6.9	
24	С.Ганболд		23.7	
25	Сор хүдэр ХХК		21.7	
26	Тэргүүн тэлмэн ХХК		32.3	
27	Хайрхан-Оргил уул ХХК		21.6	
28	Эрдэнэбаатар	11.6		
29	Эрдэнэсан	5.2		
30	Өлзийжаргал	23.7		
<b>Дүн</b>			<b>374.5</b>	